



1925

## УЛСЫН НЭГДҮГЭЭР ТӨВ ЭМНЭЛГИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2024 оны 01 сарын 19 өдөр

Дугаар А/20


Улаанбаатар хот

### Г Галын аюулгүй ажиллагааны журмыг батлах тухай

Галын аюулгүй байдлын тухай хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль, Засгийн газрын тогтоолоор баталсан "Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм", Эмнэлгийн ерөнхий захирлын 2018 оны А/270 тоот тушаалаар батлагдсан "УНТЭ-ийн хөдөлмөрийн дотоод журам"-ын 7.1.6 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эмнэлгийн тусламж үйлчилгээг найдвартай явуулах нөхцөлийг бүрдүүлэхийн тулд болзошгүй аюулыг тодорхойлж, галын аюулгүй байдлыг хангах, иргэний эрх, үүрэг, тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах УНТЭ-ийн галын аюулгүй ажиллагааны журмыг баталсугай.
2. Галын аюулгүй байдлыг хариуцан хангах, шаардагдах хөрөнгийг холбогдох зардлын ангиллаас гаргахыг Санхүү, бүртгэлийн алба (Н.Урансүрэн)-нд зөвшөөрсүгэй.
3. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж, дэмжлэгт удирдлагаар ханган ажиллахыг Төлөвлөлт, үйл ажиллагаа эрхэлсэн дэд захирал (Б.Түвшинтөр)-д даалгасугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ




Б.ХИШИГЖАРГАЛ

000092

| ГАЛЫН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ                                                                   |                                                    |            |                                 |
|---------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------|------------|---------------------------------|
|  УЛСЫН НЭГДҮГЭЭР | Хүчин төгөлдөр хэрэгжих хугацаа<br>2024/.... /.... | Хувилбар 1 | Журмын дугаар<br>УНТЭ –ИБА-ГААЖ |

Улсын нэгдүгээв төгсгөмнөлгйн ерөнхий  
захирлын 2024 онн 7 дүгээр сарын 19 –ны  
өдрийн АНТЭ дугаар тушаалын хавсралт



ГАЛЫН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

|  УЛСЫН НЭГДҮГЭЭР | ГАЛЫН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ                    |            |                                 |
|---------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------|------------|---------------------------------|
|                                                                                                   | Хүчин төгөлдөр хэрэгжих хугацаа<br>2024/.... /.... | Хувилбар 1 | Журмын дугаар<br>УНТЭ –ИБА-ГААЖ |

### БАТАЛГААЖУУЛАЛТ

Энэхүү журмыг боловсруулсан, хянасан, баталсан болоод хүчин төгөлдөр байдлыг дараах хүснэгтээр баталгаажуулна.

|               | АЛБАН ТУШААЛ                                                                               | НЭР         | ГАРЫН ҮСЭГ | ОГНОО      |
|---------------|--------------------------------------------------------------------------------------------|-------------|------------|------------|
| БОЛОВСРУУЛСАН | Инженерийн байгууламжийн албаны цахилгааны инженер, галын аюулгүй байдал хариуцсан ажилтан | Ц.Нямхишиг  |            | 2023.12.05 |
|               | Захирлын ажлын албаны ХАБЭА-н ажилтан                                                      | Ж. Урантөгс |            | 2023.12.06 |
| ХЯНАСАН       | Инженерийн байгууламжийн албаны дарга                                                      | Б.Сэржмядаг |            | 2023.12.11 |
|               | Төлөвлөлт, үйл ажиллагаа эрхэлсэн дэд захирал                                              | Б.Түвшинтөр |            | 2023.12.12 |
|               | Сургалт, эрдэм шинжилгээ, инноваци эрхэлсэн дэд захирал,                                   | П.Анхтуяа   |            | 2023.12.26 |

|                                                                                                 |                                                    |            |                                 |
|-------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------|------------|---------------------------------|
|  УЛСЫН НЭГДҮГЭЭР | <b>ГАЛЫН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ</b>             |            |                                 |
|                                                                                                 | Хүчин төгөлдөр хэрэгжих хугацаа<br>2024/.... /.... | Хувилбар 1 | Журмын дугаар<br>УНТЭ –ИБА-ГААЖ |

## ХУУЛБАРЫГ ТАРААСАН ЖАГСААЛТ

[illegible]



|                                                                                                   |                                                    |            |                                 |
|---------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------|------------|---------------------------------|
|  УЛСЫН НЭГДҮГЭЭР | ГАЛЫН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ                    |            |                                 |
|                                                                                                   | Хүчин төгөлдөр хэрэгжих хугацаа<br>2024/.... /.... | Хувилбар 1 | Журмын дугаар<br>УНТЭ –ИБА-ГААЖ |

АГУУЛГА

| Д/д | ГАРЧИГ                         | ХУУДАС |
|-----|--------------------------------|--------|
| 1   | Нийтлэг үндэслэл               | 5      |
| 2   | Нэр томьёо ба тодорхойлолт     | 5      |
| 3   | Урсгал диаграмм                | 6      |
| 4   | Үндсэн үйл ажиллагаа           | 7-10   |
| 5   | Гүйцэтгэлийн шалгуур (хэмжүүр) | 10     |
| 6   | Эрх үүрэг                      | 10     |
| 7   | Хариуцлага                     | 11     |
| 8   | Холбогдох баримт бичиг         | 11     |
| 9   | Бусад                          | 11     |
| 10  | Хавсралт                       | 12     |

| ГАЛЫН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ                                                                   |                                                    |            |                                 |
|---------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------|------------|---------------------------------|
|  УЛСЫН НЭГДҮГЭЭР | Хүчин төгөлдөр хэрэгжих хугацаа<br>2024/.... /.... | Хувилбар 1 | Журмын дугаар<br>УНТЭ –ИБА-ГААЖ |
|                                                                                                   |                                                    |            |                                 |

1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Энэхүү журмын зорилго нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хэвийн найдвартай явуулах нөхцлийг бүрдүүлэхийн тулд болзошгүй аюулыг тодорхойлж, галын аюулгүй байдлыг хангах, иргэний эрх, үүрэг, тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 Улсын нэгдүгээр төв эмнэлэг (цаашид "УНТЭ" гэх)-ийн галын аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа нь Гамшгаас хамгаалах тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Засгийн газрын тогтоолоор баталсан "Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм" болон энэхүү журмаар зохицуулагдана.

2. НЭР ТОМЪЁО БА ТОДОРХОЙЛОЛТ

- 2.1**Гал түймэр:** Монгол улсын Галын аюулгүй байдлын тухай хуульд “Хүний амь нас, эрүүл мэнд, хувь хүн болон хуулийн этгээдийн эд хөрөнгө, байгалийн баялаг, нийгэмд хохирол учруулах шаталтыг гал түймэр гэнэ” гэж тодорхойлсон.
- 2.2**Шаталт:** Ямар нэг шатах материал зориулалтын бус газар хяналтгүйгээр шатаж материалын хохирол учруулаагүй тохиолдлыг шаталт гэнэ.
- 2.3**Ноцолт:** Ямар нэг шатах материал гадны эх үүсвэрээс асахыг ноцолт гэнэ.
- 2.4**Тэсрэлт:** Ямар нэг шатах материал маш түргэн хугацаанд шатаж эвдрэл гаргахыг тэсрэлт гэнэ.
- 2.5**Дэлбэрэлт:** Ямар нэг шатах материал эгшин зуур их хэмжээний эрчим хүч ялгаруулан шатаж, цохилтын долгион үүсгэн эвдрэл гэмтэл гаргахыг дэлбэрэлт гэнэ.

|                                                                                                   |                                                 |            |                                 |
|---------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------|------------|---------------------------------|
|  УЛСЫН НЭГДҮГЭЭР | ГАЛЫН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ                 |            |                                 |
|                                                                                                   | Хүчин төгөлдөр хэрэгжих хугацаа<br>2024/.../... | Хувилбар 1 | Журмын дугаар<br>УНТЭ –ИБА-ГААЖ |

3. УРСГАЛ ДИАГРАММ





|  УЛСЫН НЭГДҮГЭЭР | ГАЛЫН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ                    |            |                                 |
|---------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------|------------|---------------------------------|
|                                                                                                   | Хүчин төгөлдөр хэрэгжих хугацаа<br>2024/.... /.... | Хувилбар 1 | Журмын дугаар<br>УНТЭ –ИБА-ГААЖ |

**4. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

- 4.1** Байгууллагын галын аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг энэхүү журмын 1.2-т заасан хууль тогтоомж, эрх зүйн акт болон байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөгөөний хүрээнд зохион байгуулна.
- 4.2 Галын аюулаас урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах:**
- 4.2.1 Байгууллагын хэмжээнд галын аюулаас урьдчилан сэргийлэхэд техникийн нарийн шалгалтыг галын байцаагч, ХАБЭА-н ажилтан, ашиглалтын инженер нартай хамтран хийнэ.
- 4.2.2 Ажилтнуудад галын аюулгүй байдлын талаар арга зүйн заавар, зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулах;
- 4.3 Галын аюулгүй байдлыг хангахад тавигдах шаардлага:**
- 4.3.1 Байгууллагын барилга нь галын аюулын үед ашиглах нэмэлт гарц буюу аврах гарц, шат, гал унтраах автомашин чөлөөтэй нэвтрэх зам, гарцтай байна.
- 4.3.2 Аянгын хүчтэй үйлчлэлийн бүсэд байрладаг бол аянганаас хамгаалах төхөөрөмжөөр тоноглогдсон байна.
- 4.3.3 Байнгын ажиллагаатай гал унтраах үндсэн болон нөөц насостой байна.
- 4.3.4 Галын хяналт, дохиолол, холбоо, агааржуулалтын болон бие даан ажиллах автомат унтраах систем, байнгын ажиллагаатай тоног төхөөрөмжөөр тоноглогдсон байна. Системийг зааврын дагуу жилд 1-ээс доошгүй удаа техникийн үйлчилгээнд хамруулна.
- 4.3.5 Архивын баримтын мэдээлэл тээгчийн терлийг харгалзан хладон эсвэл нүүрс хүчлийн хийн гал унтраагуур байрлуулна.
- 4.3.6 Гал унтраагуур нь бүрэн ажиллагаатай, нэг удаагийн лацаар лацадсан, техник бүртгэлийн паспорт, гарал үүслийн гэрчилгээ, дугаартай байна. Гал унтраагуурт үзлэг хийх, хяналт тавих, дахин цэнэглэх бүрт техникийн үйлчилгээ хийсэн бүртгэлд бүртгэнэ.
- 4.3.7 Гал унтраах анхан шатны багаж хэрэгслийг шаардлагатай үед авч ашиглах боломжтой ил харагдахуйц газарт байрлуулна.
- 4.3.8 Барилгын дотоод зохион байгуулалт, өрөө тасалгаа, байр байршлыг өөрчлөх, өргөтгөх тохиолдолд галын аюулгүй байдлыг хангуулах үүрэг бүхий байгууллагад мэдэгдэж, зөвшөөрөл авах ба барилга байгууламжийн төлөвлөлтийн зурагт өөрчлөлтийг тусгаж баталгаажуулсан байна.
- 4.3.9 Галын аюулаас урьдчилан сэргийлэх санамж, анхааруулга, гал түймэр гарсан үед аврах зам, гарцын чиглүүлэгч тэмдгийг ил харагдахуйц газарт байрлуулсан байна.
- 4.3.10 Журмын 4.3 -т заасан тоног төхөөрөмжийг батлагдсан зураг төслийн дагуу мэргэжлийн байгууллагад хандан суурилуулж, техникийн үндсэн бичиг баримтад заасан хугацаанд техникийн үйлчилгээ хийсэн тухай бүртгэл хөтөлнө.
- 4.3.11 Гал гарсан нөхцөлд хүмүүсийн аюулгүй байдлыг хангах, хурдан нүүлгэн шилжүүлэх үйлдлийг тодорхойлсон бүдүүвч зураг, зааврыг ил харагдахуйц газарт байрлуулсан байна.
- 4.3.12 Халаалтын систем хөлдсөн үед зөвхөн халуун ус, уур, элсээр гэсгээнэ. Зайлшгүй тохиолдолд галын аюулгүйн шаардлагыг бүрэн хангасан байна.

|  УЛСЫН НЭГДҮГЭЭР | ГАЛЫН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ                     |            |                                 |
|---------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------|------------|---------------------------------|
|                                                                                                   | Хүчин төгөлдөр хэрэгжих хугацаа<br>2024/...../..... | Хувилбар 1 | Журмын дугаар<br>УНТЭ –ИБА-ГААЖ |

4.3.13 Байгууллагын галын эрсдэл, аюултай ажлын байрууд, машин техник, лаборатори, архив, ажилтнуудын үйлчилгээ үзүүлэх газар, санхүү, компьютерийн төвлөрсөн хэсэг зэрэг газрууд нь гал унтраах багаж хэрэгслээр хангагдсан байна.

4.3.14 Гал унтраах багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг зориулалтын бус зүйлд ашиглах, иж бүрдлийг нь алдагдуулахыг хатуу хориглоно.

**4.4 Цахилгаан тоног төхөөрөмж, техник хэрэгслийн галын аюулгүйн байдалд тавигдах шаардлага.**

4.4.1 Барилгын цахилгаан шахуурга, хөдөлгүүр нь гадны нөлөөллөөс тусгаарласан хаалт хамгаалалт, газардуулгатай байна.

4.4.2 Цахилгаан, шугам сүлжээний кабель далд хийгдсэн байх ба ил байх тохиолдолд галд шатдаггүй сувагт сүвлэгдсэн байна.

4.4.3 Цахилгаан тоног төхөөрөмж, цахилгаан шугам сүлжээ, цахилгаан хэрэгслийн угсралт, ашиглалт, техникийн үйлчилгээ, хяналтыг холбогдох дүрэм, журамд заасны дагуу мэргэжлийн байгууллага, албан тушаалтнаар гүйцэтгүүлж, дүгнэлт гаргуулсан байна.

4.4.4 Цахилгаан шугам сүлжээнд засвар үйлчилгээ хийх тохиолдолд холбогдох ажилтан, албан хаагчдад урьдчилан мэдэгдэж, цахилгаан тоног төхөөрөмж, техник хэрэгслийг хүчдлээс салгасан байна.

4.4.5 Цахилгаан тоног төхөөрөмж, техник хэрэгсэлд аюулгүй ажиллагааны зөвлөмжийг байрлуулсан байна.

4.4.6 Цахилгаан тоног төхөөрөмж, техник хэрэгслийг ашиглаж дууссаны дараа гал түймрээс хамгаалах болон ослын гэрэлтүүлгээс бусад төхөөрөмжийг хүчдэлээс бүрэн салгана.

4.4.7 Цахилгаан хуваарилах самбарыг тусгай өрөөнд, цахилгаан хуваарилах бүдүүвч зургийг ил харагдахуйц газарт тус тус байрлуулж, зориулалтын гал хамгаалагчийн нөөц бэлтгэсэн байна.

**4.5 Галын аюулаас урьдчилан сэргийлэх зааварчилгаа өгөх:**

4.5.1 Галын аюулгүй байдлыг хангах талаар өгөх зааварчилгаа нь товчхон тодорхой байх шаардлагатай. Дараах ойлголт мэдлэгийг заавал өгч, зааварчилсан байна.

4.5.1.1 УНТЭ-ийн мөрдөж байгаа галын аюулгүйн журам;

4.5.1.2 Галын онцгой аюултай болон тамхи татах, ил гал гаргахыг хориглосон газрууд;

4.5.1.3 Гал гарсан үед авах анхан шатны арга хэмжээ; (Галын дуудлага өгөх журам, гал унтраалуур хэрэглэх, хүн эд материал аврах гэх мэт)

**4.6 Гал унтраах дүрэм:**

4.6.1 Гал түймрийн үед хүмүүсийг аврах ажлыг зохион байгуулах: Дараах нөхцөл байдал бий болсон үед зохион байгуулна.

4.6.1.1 Хүмүүст гал түймрийн ил дөл, өндөр температур шууд нөлөөлсөн буюу тэдгээрийн байгаа байр, тасалгаа нь утаа, хорт хийгээр дүүрсэн үед;

4.6.1.2 Хүмүүс аюулгүй бүсээс бие дааж гарч чадахгүй болсон байвал;

4.6.1.3 Гал түймрийн шатлага, утаа нь аврах зам гарцаар тархан дэлгэрч аюул учруулахаар болсон байвал;

4.6.2 Гал түймрийн үед хүмүүсийг аврах ажлыг гал унтраах хүн хүч, хэрэгслийн төвлөрөлт, гал унтраах тархалттай нэгэн зэрэг явуулна.

| ГАЛЫН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ                                                                   |                                                    |            |                                 |
|---------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------|------------|---------------------------------|
|  УЛСЫН НЭГДҮГЭЭР | Хүчин төгөлдөр хэрэгжих хугацаа<br>2024/.... /.... | Хувилбар 1 | Журмын дугаар<br>УНТЭ –ИБА-ГААЖ |
|                                                                                                   |                                                    |            |                                 |

- 4.6.3 Гал түймрийн дөл хүмүүст илэрхий аюул учруулж байгаа болон авралтын зам нь галын дөл, утаанд автагдсан буюу автагдахаар байвал авралтын аюулгүй байдлыг хангах зорилгоор заавал хушуугаар ус өгөх ёстой.
- 4.6.4 Хэрэв хүмүүсийг аврах, гал унтраах ажлыг нэгэн зэрэг явуулах хүн хүч, хэрэгсэл хүрэлцэхгүй байвал гал түймэр унтрааж буй бүх бүрэлдэхүүнийг зөвхөн хүмүүсийг аврах ажилд татан оруулахын зэрэгцээ нэмэлт хүн хүч, хэрэгслийг дуудна.
- 4.6.5 Гал унтраах удирдагч болон авралтын ажлыг зохион байгуулж байгаа албан тушаалтан, тусламж үзүүлэх шаардлагатай хүмүүсийн биеийн байдал, тухайн нөхцлөөс хамааран хүмүүсийг аврах дэс дараалал, аргыг тодорхойлно.
- 4.6.6 Хүмүүсийг аврах үндсэн аргууд:
- 4.6.6.1 Аврах зам, гарц нь галын дөл, утаагаар таслагдаж, аврах бусад аргыг хэрэглэх боломжгүй болсон үед аврагдаж буй хүнийг барилгын гадна талын байнгын буюу зөөврийн шат, автомеханик шат, авто өргөгч, аврах олс болон авралтын бусад төхөөрөмж, хэрэгслийн тусламжтайгаар харин ой, хээрийн түймрийн үед агаарын хөлгийг ашиглах;
- 4.6.6.2 Аюулгүй бүс, чиглэлд хүмүүсийг гаргах;
- 4.6.6.3 Өөрөө явах чадваргүй хүнийг тэврэх, үүрэх аргаар гаргах;
- 4.6.6.4 Хүүхэд, хөгшид, өвчтэй хүмүүсийг аюултай бүсээс гаргахдаа аврагч, гал сөнөөгчийг заавал дагалдуулан түүний хяналтад байнга байлгах;
- 4.6.7 Авралтын ажлыг явуулахад анхаарах зүйлс:
- 4.6.7.1 Хүмүүсийг үймээн сандралд оруулахгүй байх арга хэмжээг авч, дотоодын болон бусад мэдээлэх хэрэгслийг ашиглах;
- 4.6.7.2 Аврах ажилд байгууллагын ажилтнуудыг болон сайн дурын туслах хүчин, мэргэжлийн ангийг татан оролцуулах;
- 4.6.7.3 Эмнэлгийн яаралтай тусламжийг дуудаж, түүнийг хүрэлцэн ирэх хүртэл, аврах, гал унтраах ангийн бие бүрэлдэхүүний хүчээр аврагдсан хүмүүст эмнэлгийн анхны тусламж үзүүлэх;
- 4.6.7.4 Аврагдсан хүмүүсийг байрлуулах газрыг урьдчилан тогтоох;
- 4.6.7.5 Гал түймэр гарсан байранд хүн байгаа мэдээллийг авсан үед шатаж байгаа болон, утаанд автагдсан зэргэлдээх өрөө тасалгаа бүрт хайгуул хийх;

**4.7 Хориглох зүйлс:**

- 4.7.1 Байгууллагын хэвийн ажиллагааг хангах зорилгоор (Гараар зөөж хэрэглэх хэрэгцээнд) зарим хэмжээний тослох материал, керосин гэх мэт шатах шингэнийг төрөл тус бүрээс 20 кг- аас ихгүй хэмжээтэйг ажлын байранд хадгалахыг зөвшөөрнө.
- 4.7.2 Тос, керосин гэх мэт шатах шингэнийг нягт хаагддаг тагтай бидон саванд хийж төмөр хайрцаг буюу хаалгатай төмөр шүүгээнд хадгална.
- 4.7.3 Шатах шингэн агуулж байсан болон хүчилтөрөгчийн баллон бусад савнуудад үзлэг хийх, дотор талд нь засвар үйлчилгээ хийхдээ ил гал гаргах буюу зориулалтын бус гэрэл хэрэглэхийг хориглоно. Ийм тохиолдолд тэсрэх аюулгүй зөөврийн тусгай гэрэл хэрэглэх ёстой.
- 4.7.4 Уурын шугамууд дээрх тоосыг тогтмол цэвэрлэж байхын зэрэгцээ тус шугам дээр амархан шатаж болох зүйл тавих буюу түүнээс зүүхийт хориглоно.

|  УЛСЫН НЭГДҮГЭЭР | ГАЛЫН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ                    |            |                                 |
|---------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------|------------|---------------------------------|
|                                                                                                   | Хүчин төгөлдөр хэрэгжих хугацаа<br>2024/.... /.... | Хувилбар 1 | Журмын дугаар<br>УНТЭ –ИБА-ГААЖ |

4.8 Ажилтны сургалт

4.8.1 Онцгой байдлын газар болон ХАБЭА-н ажилтантай хамтран жилд нэг удаа галын аюулгүй ажиллагааны сургалт, дадлагыг явуулж, эмнэлзүйн төв, тасаг нэгжүүдэд давтан сургалтыг тогтмол явуулж хэвшүүлнэ.

4.9 Хяналт шинжилгээ

- 4.9.1 Журмын хэрэгжилтэд УНТЭ-ийн удирдлага болон галын аюулгүй байдлыг хангуулах үүрэг бүхий албан тушаалтан нь хяналт тавина.
- 4.9.2 Гал унтраах анхан шатны галын унтраагуур, галын гарц, дохиоллын системд хяналтыг сард нэг удаа тогтмол хийж, тэмдэглэгээ хөтөлнө.
- 4.9.3 Галын аюулгүй байдалд хяналт шалгалт хийгдсэн талаар тэмдэглэл хөтөлнө. *Хавсралт 1, “Галын аюулгүй байдлын шалгалт хийсэн тэмдэглэл”.*

5. ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР (ХЭМЖҮҮР)

5.1 Энэхүү журмын хэрэгжилт, ажлын гүйцэтгэл, үр дүн, тайлангийн үнэлгээгээр хэмжинэ.

6. ЭРХ ҮҮРЭГ

6.1 Удирдлагын эрх, үүрэг

- 6.1.1 Галын аюулгүй байдлын хууль тогтоомж, эрх зүйн актыг мөрдүүлэх, хэрэгжилтэд нь хяналт тавих, галын аюулгүйн дүрэм зөрчсөн үйлдлийг нэн даруй арилгах арга хэмжээг авах;
- 6.1.2 Галын аюулгүй байдлыг хангахад шаардагдах зардлыг жил бүрийн төсөвт тусгах, галын дохиолол, хяналтын систем, гал унтраах зориулалтын тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангах;
- 6.1.3 Байгууллагын ажилтнуудын жил бүрийн сургалтын хөтөлбөрт галын аюулаас урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааны асуудлыг тусгаж, ажилтнуудыг сургалтад хамруулах;
- 6.1.4 Шинээр ажилд орж буй ажилтанд галын аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх;
- 6.1.5 Гал түймэр гарсан тохиолдолд унтраах арга хэмжээг шуурхай зохион байгуулах, холбогдох байгууллагад мэдээлэх;
- 6.1.6 Гал түймрээс хамгаалах тоног төхөөрөмж (утаа зайлуулах систем, галын автомат систем, ус хангамж, галаас хамгаалах хаалт, хаалга, г.м)-ийг ашиглалтын байнгын бэлэн байдалд байлгана.

6.2 Ажилтны эрх, үүрэг

- 6.2.1 Галын аюулгүй байдлын дүрэм, холбогдох эрх зүйн актыг судалж, аюулгүй ажиллагааны анхан шатны мэдлэг, чадвар эзэмшсэн байх;
- 6.2.2 Тухайн ажлын байранд тавигдах галын аюулгүй байдлын шаардлагыг хангаж ажиллах;
- 6.2.3 Гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тусгагдсан өөрт хамаарах үүргийг биелүүлж ажиллах;
- 6.2.4 Ажилтан бүр гал унтраагуурыг ажиллуулж сурсан байх;

| ГАЛЫН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ                                                                      |                                                     |            |                                 |
|------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------|------------|---------------------------------|
| <br>УЛСЫН НЭГДҮГЭЭР | Хүчин төгөлдөр хэрэгжих хугацаа<br>2024/...../..... | Хувилбар 1 | Журмын дугаар<br>УНТЭ –ИБА-ГААЖ |
|                                                                                                      |                                                     |            |                                 |

7. ХАРИУЦЛАГА

- 7.1 Энэхүү журмаар тогтоосон хэм хэмжээг зөрчсөн, дүгнэлт зөвлөмжийг биелүүлээгүй, хяналт, шалгалтаар илэрсэн зөрчил дутагдыг засаж залруулаагүй, дахин давтсан ажилтанд “Хөдөлмөрийн дотоод хэм хэмжээ” бусад холбогдох журмын дагуу хариуцлага ногдуулна.
- 7.2 Ажилтан өөрийн буруутай үйлдлээс болж байгууллагад хохирол учруулсан тохиолдолд Монгол улсын хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ..

8. ХОЛБОГДОХ БАРИМТ, БИЧИГ

- 8.1 Гамшгаас хамгаалах тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Засгийн газрын тогтоолоор баталсан “Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм”;
- 8.2 Холбогдох дээд шатны байгууллагын тогтоол, тушаал, захирамж;
- 8.3 Байгууллагын “Хөдөлмөрийн дотоод журам” болон бусад холбогдох тушаал, шийдвэр;

9. БУСАД

- 9.1 Энэхүү журам нь байгууллагын Ерөнхий захирлын баталгаажуулснаар хүчин төгөлдөр үйлчилнэ.
- 9.2 Холбогдох хууль тогтоомж, тушаал шийдвэр, бодлогын баримт бичиг шинэчлэгдэх, өөрчлөгдөх бүрт хянаж, тусгах шаардлагатай өөрчлөлтийг хэлэлцэж тусгана.

